

ХЯТАДЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТОЙМ

Г.ОНОН*

Хятадын уламжлалт анагаах ухаан бол хятад үндэстний ард түмний амьдралын эм, эмнэлэг бөгөөд урт удаан хугацаанд тасралтгүй хуримтлагдаж, олон дахин нэгтгэн шинжилж, аажмаар бүрэлдэн тогтсон өвөрмөц онцлог бүхий онолын арга барилтай анагаах ухааны тогтолцоо юм. Хятадын уламжлалт анагаах ухаан гэдэг нь хятад үндэстний анагаах ухааны ерөнхий нэрийдэл бөгөөд үүнд голдуу хань үндэстний анагаах ухаан, түвд үндэстний анагаах ухаан, монгол үндэстний анагаах ухаан, уйгур үндэстний анагаах ухаан зэрэг 4 үндэстний анагаах ухаан багтдаг байна. Уламжлалт анагаах ухаан нь дотроо хань үндэстний хүн ам хамгийн олон, бичиг үсэг нь маш эрт бий болсон, түүх соёл нь нэлээд эрт үеийнх учраас хань үндэстний анагаах ухаан нь Хятад улс болон дэлхий дахинд хамгийн их нөлөөтэй болжээ.

XIX зуунд өрнөдийн анагаах ухаан Хятад улсаар дамжин орж ихэд дэлгэрсэнээс хойш хань үндэстний анагаах ухааныг бас "Хятад эмнэлэг" хэмээн нэрлээд "Европ эмнэлэг" буюу өрнө дахины анагаах ухаанаас ялгах болсон ажээ.

Хятад эмнэлэгийн түүх

Хятадын анагаах ухааны дотроос хань үндэстний анагаах ухаан нь өнө эртний түүхтэй, амьдралын туршлага болон

онолын мэдлэгээр маш баялаг байдаг. Үүнд хятад эмнэлэг нь Хатан голын сав газраас үүсэлтэй, бүр эртнээс эрдэм шинжилгээ судалгааны тогтолцоотой байсан ажээ. Хятад эмнэлэг нь өнө удаан хөгжлийн явцад, түүхийн үе шат бүрд харилцан адилгүй байснаар нэрд гарсан тоймгүй олон эмчтэй болж, улмаар эрдэм шинжилгээний маш чухал урсгалыг бий болгож, алдартай бүтээлүүд олонтой болжээ. 3000 гаруй жилийн өмнөх Инь шан төрийн үед яст мэлхийн хуяг дээр, Хятад улсын эм тан, эмнэлэг, эрүүл мэнд болон олон зүйлийн өвчин эмгэгийн тухай бичсэн байдаг. Жөү улсын үеэс үзэх, чагнах, асуух, зохицуулах зэргээр өвчин оношлох арга болон эмийн зүйл, зүү төөнүүр, мэс засал зэрэг эмчлэн засах арга барилыг хэрэглэх болсон байна.

Чинь, Хань улсын үе хүрээд "Хуан хааны дотоод судар" гэсэн нэлээд системтэй онол бүхий зохиол гарч ирсэн. Энэ ном бол одоогийн байгаа номуудаас нэн эрт гарсан Хятад эмнэлэгийн онолын сонгодог зохиол болно. Жан Зүнжиний бичсэн "тахал томуу элдэв өвчний тухай" номд төрөл бүрийн элдэв өвчнийг диалектик аргаар оношлох, эмчлэх засах зарчмыг тусгайлан өгүүлж, хойч үеийнхэндээ уламжлан клиник эмчилгээний анагаах ухаанд хөгжлийн үндэс суурийг тавьж өгсөн байна. Хань

* Г.ОНОН - ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

улсын үед мэс заслын ухаан нь нэлээд өндөр түвшинд хүрсэн байна. "Гурван улсын бичиг"-г тэмдэглэснээр алдарт эмч Хуа Түө бүх биеийг бадайруулж минчрүүлдэг "Ма фейсань" гэдэг эмийг хэрэглээд төрөл бүрийн мэс засал хийдэг байжээ. Вей улс, Жинь улс Өмнөд Умард төр (581-960 он) хүртэл судас барьж оношлох нь тодорхой амжилтанд хүрчээ. Жинь улсын үеийн нэрт эмч Ван Шүхэгийн зохиосон "Судасны судлалын тухай онол" номд 24 төрлийн судасны байдлыг хураангуйлан өгүүлсэн юм. Уг ном нь Хятадын анагаах ухаанд маш их нөлөөтэй төдийгүй гадаадад уламжлагдан иржээ. Энэ үеэс анагаах ухааны шинжилгээний төрөл зүйл нь үндсэндээ боловсронгуй болсон гэж үздэг. Зүү төөнүүрийн тусгай зохиолд "Зүү төөнүүрийн А, В судар", "Бао Пу зы" болон "Жөү Хөү фан" бичиг бол үрэл эм найруулгын аргыг төлөөлөх бүтээл юм. Эм үйлдвэрлэх талаар "Лэй Гуипаогийн төөнүүрийн онол", мэс заслын төрөлд "Лиу Жуанзын удамшилт жор", "Олон өвчний сурвалжийн тухай онол" нь өвчний шалтгааны тухай, эмчлэх арга зүйн талаар гарсан чухал бүтээл болно. "Шинээр өөрчлөлт оруулсан өвсөн эмийн товч" бол дэлхийн анхны эмийн тухай толь бичиг юм, нүдний өвчний тусгай зохиолд "Инь хай жин вэй" зэрэг үүнээс гадна Тан улсын үед бас Сүн Сымяогийн "Алтай тарнийн чухал жор" болон Вантаогийн томоохон бүтээлүүд олон бий. Сүн улсын үеийн (960-1279 он) анагаах ухааны хичээлийн сургалтанд зүү төөнүүрийн хичээл орсноор сургалтанд маш чухал өөрчлөлт гарсан. Ван Вэйгийн зохиолд "3 хүн дээр дүрсэлж үзүүлсэн зураг" байх

бөгөөд хожим бас зүү төөнүүрт зориулан хоёр том зэс хүн бүтээсэн нь хичээл сургалт явуулах үеэр оюутан сурагчдыг дадлага хийхэд тус дөхөм болж байв. Энэ үүдэлт нь хожим зүү төөнүүрийн хөгжилд маш их нөлөө үзүүлсэн. Мин улсын (1368-1644 он) энэ үед анагаах ухааны хэсэг эрдэмтэд томуу өвчин, халуун томуу, хижиг тахал зэрэг өвчнийг өөр хооронд нь ялган салгаж үзэх аргыг санаачилжээ. Чин улсын үе гэхэд халуун томууны тухай судлал харьцангуй боловсронгуй болох үе шатандаа орж, "Халуун томууны тухай өгүүлэх нь" зэрэг тусгай ном хэвлэгджээ. Мин улсын үеэс Өрнөдийн анагаах ухаан Хятадад уламжлагдан ирж, анагаах ухааны хэсэг эрдэмтэд "Хятад болон Европ эмнэлэгийг хослуулахын зорьж, шинэ үеийн Хятад Европ эмнэлэгийг уялдуулах анхны дохиолол болсон байна.

"Д
нарын
гавья
хэмээ
хотын
хэвлэ
түүхч
докто
хүүхд
Тү
ийн Т
сургу
эрхлэ
1962
аспир
ухаан
судла
Хятад
бичсэ
тэмдэ
түүхч
Монго
сурвал
зохиол
холбол
удирт
нь Мо
үед хо
Цю
бүлгий
Сюань